

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын 12-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/58/НА/-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 70433061
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас: 70432545
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Аудитор: Ц.Аззаяа
Утас: 70432545
цахим хаяг: azzayats@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
4.1 Залруулсан алдаа.....	14
4.2 Зөвлөмж	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НА	Нийцлийн аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ЖАРГАЛАНТ СУМЫН 12 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧИЙН ҮҮРЭГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
М.БАТЦЭЦЭГ ТАНАА

Ауд. од. 25 № 2/105
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Жаргалант сумын 12 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Жаргалант сумын 12 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>36,688,149.1</u>	<u>35,138,438.4</u>
33	АВЛАГА	67.0	83,862.9
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	67.0	83,862.9
35	БАРАА МАТЕРИАЛ	36,688,082.1	35,054,575.4
351	Түүхий эд материал	2,658,950.0	1,855,700.0
35130	Эм боох материал	2,658,950.0	1,855,700.0
354	Хангамжийн материал	34,029,132.1	33,198,875.4
35410	Бичиг хэргийн материал	60,000.0	175,000.0
35420	Аж ахуйн материал	-	220,400.0
35460	Хүнсний материал	2,899,200.0	1,139,700.0
35470	Бусад хангамжийн материал	31,069,932.1	31,663,775.4
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>883,523,059.4</u>	<u>875,293,738.5</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	883,523,059.4	875,293,738.5
392	Биет хөрөнгө	853,655,549.0	845,440,509.4
39201	Барилга, байгууламж, орон сууц	875,553,732.9	875,553,732.9
39202	Хуримтлагдсан элэгдэл	(48,471,112.5)	(54,797,914.2)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	36,889,509.0	36,889,509.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	(22,611,723.6)	(23,577,353.6)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	35,366,812.0	35,366,812.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	(23,468,668.8)	(24,391,276.6)
39217	Ном	397,000.0	397,000.0
393	Биет бус хөрөнгө	29,867,510.3	29,853,229.1
39301	Програм хангамж	457,000.0	457,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(109,489.7)	(123,770.9)
39303	Бусад биет бус хөрөнгө	29,520,000.0	29,520,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>920,211,208.5</u>	<u>910,432,176.9</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>52,500.0</u>	<u>167,041.0</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	52,500.0	167,041.0

413	Өглөг	52,500.0	167,041.0
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	52,500.0	12,932.0
4136	Бусад өглөг	-	154,109.0
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	154,109.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	920,158,708.5	910,265,135.9
51	Засгийн газрын хувь оролцоо	920,158,708.5	910,265,135.9
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	29,520,000.0	29,520,000.0
51101	Өмч: - төрийн	29,520,000.0	29,520,000.0
512	Хуримтлагдсан үр дүн	260,693,948.7	250,800,376.2
51210	Өмнөх үеийн үр дүн	260,693,948.7	260,693,948.7
51220	Тайлант үеийн үр дүн	-	(9,893,572.6)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	629,944,759.8	629,944,759.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	920,211,208.5	910,432,176.9

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	458,752,540.0	474,298,247.0
13.00	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	458,752,540.0	474,298,247.0
1,310.00	Улсын төвлөрсөн төсвөөс	381,617,800.0	407,892,700
131,007.00	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	381,617,800.0	407,892,700.0
1,311.00	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,227,600.0	5,416,947.0
131,103.00	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,227,600.0	-
131,104.00	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,416,947.0
1,320.00	Орон нутгийн төсвөөс санхүүжих	60,893,400.0	60,988,600
132,001.00	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	60,893,400.0	60988600
1,340.00	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	13,740.0	-
134,001.00	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	13,740.0	-
2.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	463,787,660.4	484,635,662.9
21.00	УРСГАЛ ЗАРДАЛ	463,787,660.4	484,635,662.9
210.00	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	449,202,747.9	437,034,950.2

2,101.00	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	295,628,701.6	305,855,015.0
210,101.00	Үндсэн цалин	202,499,481.6	180,062,872.0
210,102.00	Нэмэгдэл	68,372,850.0	75,332,929.2
210,103.00	Унаа хоолны хөнгөлөлт	2,826,000.0	2,630,000.0
210,104.00	Урамшуулал	21,930,370.0	47,829,213.8
2,102.00	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,293,796.6	40,570,496.3
210,201.00	Тэтгэврийн даатгал	25,599,739.1	27,668,693.0
210,202.00	Тэтгэмжийн даатгал	2,953,933.5	3,210,619.1
210,203.00	ҮОМШӨ-ний даатгал	2,363,146.8	2,528,175.1
210,204.00	Ажилгүйдлийн даатгал	612,293.6	1,012,062.7
210,205.00	Эрүүл мэндийн даатгал	5,764,683.5	6,150,946.4
2,103.00	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,417,587.1	60,699,643.1
210,301.00	Гэрэл, цахилгаан	1,981,373.1	1,678,157.1
210,302.00	Түлш, халаалт	38,550,300.0	47,331,570.0
210,303.00	Цэвэр, бохир ус	12,885,914.0	11,689,916.0
2,104.00	Хангамж, бараа материалын зардал	1,441,700.0	1,663,500.0
210,401.00	Бичиг хэрэг	1,151,700.0	916,100.0
210,402.00	Тээвэр, шатахуун	100,000.0	54,800.0
210,403.00	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	190,000.0	250,000.0
210,406.00	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	442,600.0
2,105.00	Нормативт зардал	27,607,370.0	18,231,275.0
210,501.00	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	2,012,650.0
210,502.00	Хоол, хүнс	26,110,070.0	15,336,825.0
210,503.00	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,497,300.0	881,800.0
2,106.00	Эд хогшил, урсгал засварын зардал	1,749,700.0	1,120,000.0
210,604.00	Урсгал засвар	1,749,700.0	1,120,000.0
2,108.00	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	565,300.0	557,700.0
210,801.00	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	125,700.0
210,802.00	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	565,300.0	432,000.0
2,109.00	Бараа үйлчилгээний бусад зардал	31,498,592.6	8,337,320.9
210,902.00	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	248,000.0	108,000.0
210,903.00	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	31,250,592.6	8,229,320.9

213.00	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,584,912.5	47,600,712.7
2,132.00	Бусад урсгал шилжүүлэг	13,740.0	3,550,872.0
213,202.00	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	13,740.0	-
213,204.00	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	3,550,872.0
2,133.00	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,571,172.5	44,049,840.7
213,303.00	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,571,172.5	44,049,840.7
3.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(5,035,120.4)	(10,337,415.9)
5.00	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(5,035,120.4)	(10,337,415.9)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	29,520,000.0	629,944,759.8	233,650,717.2	893,115,476.9
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	29,520,000.0	629,944,759.8	233,650,717.2	893,115,476.9
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	27,043,231.6	27,043,231.6
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	29,520,000.0	629,944,759.8	260,693,948.7	920,158,708.5
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	29,520,000.0	629,944,759.8	260,693,948.7	920,158,708.5
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	29,520,000.0	629,944,759.8	260,693,948.7	920,158,708.5
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(9,893,572.6)	(9,893,572.6)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	29,520,000.0	629,944,759.8	250,800,376.2	910,265,135.9

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	458,752,540.0	474,298,247.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	458,752,540.0	474,298,247.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	381,617,800.0	407,892,700
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	381,617,800.0	407,892,700
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,227,600.0	5,416,947.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,гүүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,227,600.0	-

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,416,947.0
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	60,893,400.0	60,988,600
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	60,893,400.0	60,988,600
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	13,740.0	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	13,740.0	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	458,752,540.0	474,298,247.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	458,752,540.0	474,298,247.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	444,167,627.5	426,697,534.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	295,748,143.8	305,749,448.0
210101	Үндсэн цалин	202,618,923.8	197,129,017.8
210102	Нэмэгдэл	68,372,850.0	79,431,946.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,826,000.0	2,270,000.0
210104	Урамшуулал	21,930,370.0	26,918,484.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,241,296.6	40,645,318.3
210201	Тэтгэврийн даатгал	25,593,596.6	28,333,218.3
210202	Тэтгэмжийн даатгал	2,846,200.0	3,078,000.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,347,100.0	2,462,500.0
210204	Ажилгүйдлийн даатгал	586,800.0	615,600.0
210205	Эрүүл мэндийн даатгал	5,867,600.0	6,156,000.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,417,587.1	60,699,643.1
210301	Гэрэл, цахилгаан	1,981,373.1	1,678,327.1
210302	Түлш, халаалт	38,550,300.0	47,331,400.0
210303	Цэвэр, бохир ус	12,885,914.0	11,689,916.0
2104	Хангамж, бараа материалын зардал	22,068,300.0	1,743,775.0
210401	Бичиг хэрэг	1,211,700.0	109,300.0
210402	Тээвэр, шатахуун	100,000.0	54,800.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	190,000.0	75,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	866,075.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,566,600.0	638,600.0
2105	Нормативт зардал	33,129,300.0	14,896,850.0

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,658,950.0	345,825.0
210502	Хоол, хүнс	28,973,050.0	13,577,325.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,497,300.0	973,700.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,749,700.0	1,200,000.0
210604	Урсгал засвар	1,749,700.0	1,200,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	565,300.0	557,700.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	125,700.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	565,300.0	432,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	248,000.0	1,204,800.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	248,000.0	1,204,800.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,584,912.5	47,600,712.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,740.0	3,550,872.0
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	13,740.0	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	3,550,872.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,571,172.5	44,049,840.7
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,571,172.5	44,049,840.7
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	468,881,300.0	424,831,459.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	468,881,300.0	424,831,459.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	468,881,300.0	424,831,459.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	307,800,900.0	305,749,448.0
210101	Үндсэн цалин	197,891,600.0	197,129,017.8

210102	Нэмэгдэл	85,918,500.0	79,431,946.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,402,700.0	2,270,000.0
210104	Урамшуулал	21,588,100.0	26,918,484.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,553,100.0	40,645,318.3
210201	Тэтгэврийн даатгал	29,241,000.0	28,333,218.3
210202	Тэтгэмжийн даатгал	3,078,000.0	3,078,000.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,462,500.0	2,462,500.0
210204	Ажилгүйдлийн даатгал	615,600.0	615,600.0
210205	Эрүүл мэндийн даатгал	6,156,000.0	6,156,000.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,788,600.0	60,699,643.1
210301	Гэрэл, цахилгаан	1,767,200.0	1,678,327.1
210302	Түлш, халаалт	47,331,400.0	47,331,400.0
210303	Цэвэр, бохир ус	11,690,000.0	11,689,916.0
2104	Хангамж, бараа материалын зардал	955,000.0	877,700.0
210401	Бичиг хэрэг	109,300.0	109,300.0
210402	Тээвэр, шатахуун	54,800.0	54,800.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	89,800.0	75,000.0
210404	Ном, хэвлэл	62,500.0	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	638,600.0	638,600.0
2105	Нормативт зардал	55,690,100.0	14,896,850.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	353,900.0	345,825.0
210502	Хоол, хүнс	54,362,500.0	13,577,325.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	973,700.0	973,700.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	200,000.0	200,000.0
210604	Урсгал засвар	200,000.0	200,000.0
2107	Томилолт, зочны зардал	113,200.0	-
210702	Дотоод албан томилолт	113,200.0	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	575,600.0	557,700.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	143,600.0	125,700.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.0	432,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,204,800.0	1,204,800.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,204,800.0	1,204,800.0

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	468,881,300.0	424,831,459.4
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	407,892,700.0	363,931,817
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	407,892,700.0	363,931,817
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	60,988,600.0	60,899,644
132001	Орон нутгийн төсвөөс	60,988,600.0	60,899,644
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0	1.0
610001	Төсвийн байгууллага	1.0	1.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23.0	23.0
620001	Удирдах ажилтан	1.0	1.0
620002	Гүйцэтгэх ажилтан	16.0	16.0
620003	Үйлчлэх ажилтан	6.0	6.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	175.0	175.0
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	175.0	175.0
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	175.0	175.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	16,227,600.0	5,416,947.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	16,227,600.0	5,416,947.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,227,600.0	1,866,075.0
2104	Хангамж, бараа материалын зардал	16,227,600.0	866,075.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	866,075.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,227,600.0	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,000,000.0
210604	Урсгал засвар	-	1,000,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	3,550,872.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	3,550,872.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	3,550,872.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	16,227,600.0	5,416,947.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,227,600.0	5,416,947.0

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,227,600.0	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,416,947.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймгийн Жаргалант сумын 12-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор Ц.Аззаяа 2022 оны 01 дүгээр сарын 24-нээс 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ховд аймгийн Жаргалант сумын 12-р цэцэрлэг нь 2021-2022 оны хичээлийн жилд “Багш ажилчдын хандлагыг сайжруулж, хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж хичээл, сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах” зорилгын хүрээнд 5 зорилт, 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны нийт зардлын 484.6 сая төгрөгөөс 1.5 хувиар тооцон 7.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5.1 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Ховд аймгийн Жаргалант сумын 12-р цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9.8 сая төгрөгөөр буюу 1.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

2021 оны 12 дугаар сарын шимтгэл төлөлтийн тооцоо хийхэд 0.05 сая, татварт 0.05 сая төгрөгөөр илүү шилжүүлсэн тул 0.1 сая төгрөгийн авлага үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 35.0 сая төгрөг болж 1.6 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 17.9 сая, хандиваар 0.4 сая нийт 18.3 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үйл ажиллагаандаа 20.0 сая төгрөгийн материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 883.5 сая төгрөг, оны эцэст 875.2 сая төгрөг болж 8.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардалтай холбоотой байна.

Тайлант онд өр төлбөр 0.2 сая төгрөг болж 0.1 сая төгрөгөөр өссөн нь хувь хүмүүст төлөх өглөг нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 920.1 сая төгрөг байсан ба оны эцэст 910.2 сая төгрөг болж өөрчлөгдсөн нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 910.2 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Ховд аймгийн Жаргалант сумын 12-р цэцэрлэгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тусгай 507.9 сая төгрөгөөр, нийт зарлагыг 507.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас тус байгууллагын төсвийг 503.9 мянган төгрөгөөр батлан ирүүлжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 503.9 сая төгрөгийн төсөв баталснаас тусгай зориулалтын шилжүүлгээр 442.9 сая төгрөгийг, орон нутгийн төсвөөс 60.9 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээр 408.9 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 59.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 424.8 сая төгрөгийг зарцуулж, 44.0 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 424.8 сая төгрөг буюу 91.4 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 2.0 сая төгрөгөөр, байр ашиглалттай тогтмол зардлыг 0.1 сая төгрөгөөр, хоолны зардлын 40.8 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны байгууллагаас 5.4 сая төгрөгийн санхүүжилтийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн дээрх эх үүсвэрүүдийг холбогдох арга хэмжээнд зарцуулжээ.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих мэдээллийг 62.5 хувьтай мэдээлсэн байна. Ховд аймгийн Жаргалант сумын 12-р цэцэрлэг нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 7 гүйлгээ, зарлагын 5 гүйлгээний мэдээллийг мэдээлээгүй зөрчил илэрлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 0.6 сая төгрөгийн 3 зөвлөмж өгөгдсөнийг бүрэн биелүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилт хангагдаагүй алдаа зөрчил илэрснийг, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулсан алдаа байхгүй болно.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт2: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянахад 5 сая төгрөгөөс дээш үнийн бүхий орлогын гүйлгээнд 6-12 дугаар сарын санхүүжилтийн мэдээлэл, зарлагын 5 гүйлгээг мэдээлээгүй зөрчил илэрлээ. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.5 дах заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хуулийн хугацаанд нь оруулж баталгаажуулж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая. төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Жаргалант сумын 12-р цэцэрлэг	1	-	-	-	-	-	-	-	1	-

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР